

Ажлын байрандаа аливаа дарамтлалд өртөж байна уу?

Жирэмслэлт, төрөлт, хүүхэд асрах чөлөө авсан гэх мэт шалтгаанаар ажлаас халж зүй бусаар харьцахыг хуулиар хориглодог



Ажилчныг иргэншил (Япон ба гадаад), оршин суух статусаар ялгаварлаж, **“Жирэмсэн болвол ажлаас хална” гэдэг нь хууль бус үйлдэл юм !**

“Жирэмсний амралт, төрсний дараах амралт өгөхгүй” гэж хэлсэн

“Богино цагаар ажиллах бол цагийн ажилтан бол” гэж хэлсэн

Хүүхэд асрах чөлөө авсан чинь албан тушаал бууруулсан

Жирэмсний болон төрсний дараах амралт авсан чинь цалин хасагдсан


Жирэмсэн болсноо мэдэгдтэл “Визний сунгалт хийж өгөхгүй” гэж хэлсэн

“Эх үрийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ”-г ашиглан амралтаа авсан чинь ажлаас халагдсан

Жишээлбэл.....

Эдгээр шалтгаар

- Жирэмсэн болсон, хүүхэд гаргасан
- Жирэмсний хордлогоос болж ажлаас чөлөө авсан
- Жирэмсний болон төрсний дараах чөлөө авсан г.м.



Эдгээр байдлаар зүй бус харьцсан бол хууль зөрчсөн болно !

- Ажлаас халсан
- Оршин суух зөвшөөрлийг сунгах бүрдүүлэлт хийж өгөөгүй
- Цалин хассан г.м.

“Төрсний дараа (хүүхэд асрах чөлөө авсны дараа ажилдаа буцаж орох) ч гэсэн үргэлжлүүлэн ажилламаар байна!” гэдгээ ажлын газартаа өөрийн үзэл бодлоо тод хэлж ойлгуулаарай

Жирэмсэн, төрөх үед ашиглаж болох тогтолцооны талаарх мэдээллийг арын хуудаснаас үзнэ үү.

Түүнчлэн.....

Ажлын байран дахь дарамт шахалтанд өртөж ямар арга хэмжээ авахыг мэдэхгүй байгаа бол холбогдох товхимолыг үзнэ үү.

Жирэмсэн, төрөлт, хүүхэд асрах үед ашиглаж болох тогтолцоо*

Жирэмсэн, хүүхэд гаргасан ажилчны ашиглаж болох тогтолцоо, арга хэмжээ	Хүүхэд асарч буй эрэгтэй эмэгтэй ажилчдын ашиглаж болох тогтолцоо, арга хэмжээ (зарим хэсэг)
<p>◆ Жирэмсний болон төрсний дараах амралт Төрөх мөчлөгөөс 6 долоо хоногийн өмнөөс амралтаа авч болно. Төрсний дараа зарчмын хувьд 8 долоо хоног ажиллаж болохгүй</p> <p>◆ Биед амар ажлын байраар солих Жирэмсэн үед эх үрийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс биед амар ажлын байранд хуваарилах хүсэлт гаргаж болно.</p> <p>◆ Эх үрийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ Эх үрийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдах эмчийн заавар авсан бол ажлын газартаа мэдэгдэж арга хэмжээ аваарай.</p> <p>◆ Хортой ажлын орчинд ажиллуулахгүй байх Хүнд юм өргөх ажил, хорт хий цацагдсан орчинд эмэгтэй ажилчин ажиллуулж болохгүй.</p> <p>◆ Хүүхэд асрах цаг 1 нас хүрээгүй нярай хүүхэдтэй эмэгтэйд завсарлааны цагаас гадна өдөрт 2 удаа тус бүр 30 минутын хүүхэд асрах чөлөө авч болдог.</p> <p>◆ Илүү цаг болон амралтын өдрүүд, шөнийн ээлжинд ажиллуулахгүй байх Илүү цаг болон амралтын өдрүүд болон шөнийн ээлжинд ажиллуулахгүй байх хүсэлт гаргаж болно.</p>	<p>◆ Хүүхэд асрах амралт Зарчмын хувьд хүүхдээ 1 нас хүрэхээс 1 хоногийн өмнө хүртэл ажлаас чөлөө авч болно. Амралтаа 2 хувааж авч болно.</p> <p>◆ Эрэгтэй хүний хүүхэд асрах амралт (Эхнэрээ төрсний дараа хүүхэд асрах амралт авах) Хүүхэд төрсний дараа 8 долоо хоногийн дотор 4 долоо хоног хүртэл, 2 хувааж чөлөө авч болно.</p> <p>◆ Богино цагаар ажиллах боломжтой 3 хүртэлх насны хүүхэд өсгөж байгаа хүн хүсэлт гаргавал богино цагаар ажиллах боломжтой.</p> <p>◆ Өвчилсөн, гэмтэж, бэртсэн хүүхэд асрах амралт Сургуулийн өмнөх насны хүүхэд өсгөж байгаа ажилчин өвчилсөн, гэмтэл бэртсэн хүүхдээ асрах хэрэгтэй бол, жилд 5 өдөр (2-оос дээш хүүхэдтэй бол 10 өдөр хүртэл), 1 цагийн нэгжээр амралтын чөлөө авч болно.</p> <p>◆ Илүү цагаар ажиллуулахгүй байх 3 хүртэлх насны хүүхэд өсгөж байгаа хүн илүү цагаар ажиллуулахгүй байх хүсэлт гаргаж болно.</p>

* Тогтолцооны талаар тоймлож оруулав. Дэлгэрэнгүйг ажлын газар болон Хөдөлмөрийн товчооноос лавлана уу.

Тогтолцооны талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл, эсвэл жирэмслэлт, төрөлт, хүүхэд асрах чөлөө авахтай холбоотой асуудал гарвал нийслэл, мужийн хөдөлмөрийн товчооны Жендэрийн эрх тэгш байдлыг хангах алба/тасгаас зөвлөгөө авна уу. Зөвлөгөөг нэргүйгээр хүлээж авна. Зөвлөгөө авагчийн нууцлалыг хамгаална. Хэрэв хүсвэл бид танай ажлын газарт хандаж хууль тогтоомж, тогтолцооны талаар тайлбарлаж өгөх боломжтой.

Зөвлөгөө өгөх газар: Нийслэл, мужийн Хөдөлмөрийн товчооны Жендэрийн эрх тэгш байдлыг хангах алба/тасагийн холбоо барих утас (зөвлөгөө авахад үнэгүй)

Нийслэл, мужууд	Утасны дугаар	Нийслэл, мужууд	Утасны дугаар	Нийслэл, мужууд	Утасны дугаар	Нийслэл, мужууд	Утасны дугаар
Хоккайдо	011-709-2715	Токио	03-3512-1611	Шига	077-523-1190	Кагава	087-811-8924
Аомори	017-734-4211	Канагава	045-211-7380	Киото	075-241-3212	Эхимэ	089-935-5222
Иватэ	019-604-3010	Ниигата	025-288-3511	Осака	06-6941-8940	Коочи	088-885-6041
Мияги	022-299-8844	Тояма	076-432-2740	Хиого	078-367-0820	Фүкүока	092-411-4894
Акита	018-862-6684	Ишикава	076-265-4429	Нара	0742-32-0210	Сага	0952-32-7218
Ямагата	023-624-8228	Фүкүи	0776-22-3947	Вакаяма	073-488-1170	Нагасаки	095-801-0050
Фүкүшима	024-536-4609	Яманашин	055-225-2851	Тоттори	0857-29-1709	Күмамото	096-352-3865
Ибараки	029-277-8295	Нагано	026-227-0125	Шиманэ	0852-31-1161	Ойта	097-532-4025
Точиги	028-633-2795	Гифү	058-245-1550	Окаяма	086-225-2017	Миязаки	0985-38-8821
Гүнма	027-896-4739	Шизүока	054-252-5310	Широсима	082-221-9247	Кагошима	099-223-8239
Сайтама	048-600-6210	Айчи	052-857-0312	Ямагүчи	083-995-0390	Окинава	098-868-4380
Чиба	043-221-2307	Миэ	059-226-2318	Токушима	088-652-2718		

Зөвлөх цаг: 8:30-17:15 (Бямба, ням, баярын өдрүүд, жилийн эцсийн болон эхний амралтын өдрүүдээс бусад)

【Лавлагаа】 Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн тойм



Англи хэл



Хятад хэл



Португал хэл



Вьетнам хэл



Япон хэл